

**“МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай Г
болон хурлыг хүчин төгөлдөр бусд тооцох тухай

Монголын Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 300 000 хувьцаа эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр оролцож нийт гаргасан энгийн хувьцааны 300 000. ширхэг буюу 1% хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Хурлын ирц хүрээгүй тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бусд тооцож хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлохыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТ
КОМИССЫН ДАРГА
ЭЗЭМШИГЧДИЙН
ХУВЬЦАА



/М.НАВЧАА /

УТТ0271.25257201

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар___

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот Хан-уул дүүрэг 15 хороо, Гэгээнтэн цогцолбор 215 тоотод болов.

Хуралд :

Хувьцаа эзэмшигч З.Номундарь 300 000 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 1 % хувийн хувьцаа эзэмшигч, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Навчаа, тооллогын комиссын гишүүд болох Ю.Туяацэцэг нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг М.Навчаа удирдав.

Хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцав.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья.

Тооллогын комиссын гишүүн Ю.Туяацэцэг ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын тогтоолоос үзэхэд хурлын ирц 1% байгаа тул Монгол улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц хурал хүчин төгөлдөр болох хувьд хүрэхгүй байгаа нь Компанийн тухай хуулийн 96.3-д Энэ хуулийн 69.1-д заасан хувь хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг төлөөлөн удирдах зөвлөл төвлөх бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно. Тиймээс ТУЗ-ийн хурал хуралдаж хойшлогдсон хурлын товийг зарлах хэрэгтэй болж байна.

З.Номундарь: Нийт хувьцааны дийлэнх хувийг эзэмшиж байгаа Yч.Кoуanaги-той холбогдох гэж оролдсон уу, хурлын товийг япондох хаягруу шуудангаар явуулсан юмуу, гол хувьцаа эзэмшигч хуралд оролцохгүй байгаа нь компанийн цаашдын асуудал маш хүнд байна. Тиймээс хуулийн хүрээнд авах арга хэмжээг авч ажиллах шаардлага гарц ирж байна.

Хурлын дарга М.Навчаа: Японруу ээлжид хурлын товийг DHL олон улсын шуудангийн компаниар явуулсан байгаа.

З.Номундарь: За ойлголоо энэ үүсээд байгаа асуудалд хуулийн хүрээнд ямар шийдэл байна судалцгаая.

Хурал 13.35 өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Handwritten signature

/Ю.ТУЯАЦЭЦЭГ /

“МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ИРЦИЙН БАТАЛГААЖИЛТ

2020 оны 5 дугаар сар 20

Дугаар 01


Улаанбаатар хот

№	Овог нэр	Регистрийн №	Хувьцааны тоо	Төлөөлөл	Гарын үсэг
1	З.Номундарь	УС79031826	300 000	Өөрийн биеэр	

КОМИССЫН ДАРГА



/М.НАВЧАА/



ТУЗ-ИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 46,5 дахь заалт, 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК” ХК-ийн 2019 оны тайлан тэнцлийн ний хөрөнгийг 159,419,555.45 төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 142,199.72 төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 159,277,355.73 төгрөг, алдагдал (-35,770,141.42) тус тус тооцож тайлан тэнцлийн дүнг баталсугай.
2. Компани нь тус онд алдагдалтай ажилласан тул 2019 онд ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.
3. Ногдол ашиг хуваарилахгүй талаар хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэхийг /Ю.Туяацэцэг/-т даалгасугай.
4. 2020 онд бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлж, дахин хөрөнгөжих төлөвлөгөөг батлуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Л.Гүндэгмаа/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



З.НОМУНДАРЬ